



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 10 өдөр

Дугаар 4/08

Улаанбаатар хот

Шинжлэн шалгах багийг томилох тухай

Иргэний нисэхийн тухай Монгол улсын хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралтын 5.1, Иргэний нисэхийн багц дүрэм 203-ын 8.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хүннү Эйр компанийн JU-8883 бүртгэлийн дугаартай Фоккер-50 маягийн агаарын хөлөг 2018 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Овоот-Улаанбаатар чиглэлийн нислэгийн үед баруун хөдөлгүүр татгалзсан шалтгааныг тогтоох шинжлэн шалгах багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Шинжлэн шалгах багийн ахлагч:

Х.Наранхүү, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны ахлах шинжээч

Гишүүд:

О.Бат-Орших, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

Б.Чинзориг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

И.Энхчулуун, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээч

П.Гэрэлчимэг, Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны бичлэг тайлагч

2. Шинжлэн шалгах ажиллагааг Чикагогийн конвенцийн 13 дугаар хавсралт, албаны "Aircraft Accident Investigation Policy and Procedures Manual"-ын дагуу хийж гүйцэтгэхийг багийн ахлагч (Х.Наранхүү)-д үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ

2018 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 4/10

Улаанбаатар хот

Сахилга хариуцлага, дэг журмыг  
чангатгах тухай

Монгол улсын Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн “Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” 258 дугаар тогтоолыг үндэслэн ажилтан албан хаагчдын цаг ашиглалт, ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг чанд сахиулах зорилгоор ТУШААХ нь:

1. Албан хаагчид албан томилолтын явцад, ажлын болон ажлын бус цагаар ажлын байранд согтууруулах ундаа хэрэглэх, согтууруулах ундаа, мансууруулах бодис, галт болон хүйтэн зэвсэг, тэсэрч дэлбэрэх болон шатамхай бодис, хэрэгслийг нэвтрүүлэх, хадгалах, хэрэглэх, ашиглахыг хатуу хориглосугай.

2. Ажлын цагийг чанд баримталж, ажил таслах, хоцрох, эрт тарах, ажил цалгардуулах явдлыг таслан зогсоож, Хөдөлмөрийн дотоод журмыг чанд мөрдөж ажиллахыг нийт ажилтнуудад даалгасугай.

3. Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн дагуу ажлаа бүрэн, оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, биелэлтийг ханган ажиллаж, өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлж, үр дүнг тогтмол мэдээлэх, хийсэн ажлынхаа гүйцэтгэл, үр дүнг бүрэн хариуцаж ажиллахыг албаны нийт ажилтнуудад үүрэг болгосугай.

4. Албаны хэмжээнд дотоод хяналтыг тавьж, Хөдөлмөрийн дотоод журам зөрчсөн үйлдэл, илэрсэн зөрчил, дутагдлыг шуурхай арилгаж, буруутай ажилтанд тухай бүр хариуцлага тооцож, ажиллахыг шинжлэн шалгах тасаг /Х.Наранхүү/ болон захиргаа, судалгааны тасаг /П.Гэрэлчимэг/-т үүрэг болгосугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 12 сарын 03 өдөр

Дугаар

A/15

Улаанбаатар хот

**Шинжээчийн мэргэжлийн ур чадварыг  
хадгалах журмыг батлах тухай**

Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ICAO/-ын баримт бичиг /DOC9756, P1/-ийн 2.4.2, 2.4.3 дахь заалт, Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 171 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм”-ийн 4.4.26 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны “Шинжээчийн мэргэжлийн ур чадварыг хадгалах журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Шинжээчийн мэргэжлийн ур чадварыг хадгалах журмыг 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг ахлах шинжээч, шинжээч нарт даалгасугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН



**НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ  
ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГЫН  
ТУШААЛ**

2018 оны 12 сарын 04 өдөр

Дугаар

A/16

Улаанбаатар хот

**Шинжээчийн ёс зүйн хэм хэмжээний  
дүрмэнд өөрчлөлт оруулах тухай**

Зам, Тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн 171 тоот тушаалын нэгдүгээр хавсралт "Нислэг-техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны дүрэм"-ийн 4.4.26 дахь заалтыг үндэслэн нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны шинжээчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоохын тулд ТУШААХ нь:

1. Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны "Шинжээчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм"-нд нэмэлт өөрчлөлт оруулан хавсралт ёсоор баталсугай.

2. "Шинжээчийн ёс зүйн хэм хэмжээний дүрэм"-ийг 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс эхлэн мөрдөж, хэрэгжилтэнд анхаарч ажиллахыг шинжээч нарт даалгасугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Шинжээчийн ёс зүйн дүрэм батлах тухай" Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны даргын 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А/05 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

АЛБАНЫ ДАРГА БӨГӨӨД  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ



Ж.ЦОЛМОН